

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

**САЛБАРЫН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ЭМЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН ХЯНАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ
БАЗАРЖАВ ОВОГТОЙ БАЙГАЛЬМААГИЙН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь	
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин(биелэлт)				
Зорилт 1. Салбарын хяналтын эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.									
1.	Арга хэмжээ 1.1. Эмчилгээний чанарын хяналтын чиглэлээр 2024 онд хийсэн хяналт шалгалтын дунд үндэслэн холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг судлан нэгтгэж, саналыг Хяналт, үнэлгээний үндэсний хороонд хүргүүлнэ.	Хүргүүлсэн тайлан, санал	2023 оны тайлан, санал	2024 оны хяналт шалгалтын дунд үндэслэн хууль тогтоомжийн хэрэгжилтийг гарган, холбогдох саналыг боловсруулж XYX-нд хүргүүлсэн байна.	Эмчилгээний чанарын хяналтын чиглэлээр 2024 онд хийсэн төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын дунг үндэслэн холбогдох Эрүүл мэндийн тухай, Зөрчлийн тухай хууль тогтоомжид 6, стандарт, дүрэм, журмын хэрэгжилтийг боловсронгуй болгох 7 саналыг боловсруулж, нэгтгэлд өгч тусгуулсан.		2025.01.02 2025.03.30	100%	

	Арга хэмжээ 1.2. “Эмнэлгийн оношилгоо, эмчилгээний чанар, аюулгүй байдлыг шалгах” 10.1.3, 10.1.6, 10.1.7 кодтой хяналтын хуудсыг шинэчилж, эмнэлзүйн лабораторийн оношилгоо, эмчилгээний чанар, аюулгүй байдлыг шалгах 1 хяналтын хуудсыг шинээр боловсруулж батлуулна.	Шинэчлэн боловсруулс ан хяналтын хуудсын тоо			-ЭМС-ын 2025 оны А/26 дугаар тушаалаар Эмчилгээний чанарын хяналтын чиглэлээр өрх, сум, тосгон, түргэн тусламж, эмнэлзүйн лабораторийн эмнэлгийн оношилгоо, эмчилгээний чанар, аюулгүй байдлыг шаллгах 3 хяналтын хуудсыг шинэчилж, 1 хяналтын хуудсыг шинээр боловсруулж, батлуулан хяналт шалгалтад ашиглаж байна. -Олон улсын Эрүүл мэндийн лаборатори-Чанар ба чадавхид тавих шаардлага MNS ISO 15189:2024 стандарт, 8 Эрүүл мэндийн сайдын тушаал, заавар шинэчилж гарсантай холбоотойгоор өрх, сум, тосгон, түргэн тусламж, эмнэлзүйн лабораторийн эмнэлгийн оношилгоо, эмчилгээний чанар, аюулгүй байдлыг шалгах (10.1.3, 10.1.6, 10.1.7 кодтой хяналтын хуудсанд 59 өөрчлөлт, 1(10.1.11) хяналтын хуудсанд шинээр (10.1.11) кодтой 50 асуудлаар нийт 4 хяналтын хуудсанд шинээр болон нэмэлт өөрчлөлт оруулж, 25 эмчилгээний чанарын хяналтын улсын байцааг нарын дунд хяналтын хуудасны шинэчилсэн төслийг хэлэлцүүлж, санал авч тусгасан. -Эмчилгээний чанарын хяналтын чиглэлээр хяналтын хуудас хэрэглэх зөвлөмжийг боловсруулж, салбарын хяналтын газрын даргаар батлуулж, аймаг, нийслэлийн эмчилгээний чанарын хяналтын улсын байцаагч наарт зориулан 6 бүлэг 99 асуулт бүрээр зөвлөмж бичиж хүргүүлсэн.	100%
2.		ЭМС-ын 2024 оны А/76 тушаалаар батлуулсан 11 хяналтын хуудас	3 хяналтын хуудсыг шинэчлэн, 1 хяналтын хуудсыг шинээр боловсруулж батлуулсан байна		2025.01.02 2025.02.25	

Зорилт 2. Хяналт, үнэлгээний үндэсний хорооны 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан хяналт шалгалтын төлөвлөгөө болон хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.	Арга хэмжээ 2.1. Анхан шатлалын тусламж үйлчилгээ үзүүлдэг их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 119 эмнэлгүүдэд төлөвлөгөөт хяналт шалгалт хийх ажлыг зохион байгуулна.	Хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга	2024 онд төлөвлөгөөт хяналт шалгалтын танилцуулга гаргасан.	Хяналтын шалгалтын нэгдсэн танилцуулга гаргасан байна.	Улсын хэмжээнд эхний хагас жилд Анхан шатлалын тусламж үйлчилгээ үзүүлдэг 115 эмнэлэгт хийж, хамралт 96 хувтай байна. Шалгалтад сум, тосгоны эрүүл мэндийн төв -95 (СТЭМТ), өрхийн эрүүл мэндийн төв 20 (ӨЭМТ) хамрагдлаа. Дээрх эмнэлгүүдэд 2 хяналтын хуудсаар хяналт шалгалт хийхэд 8 эмнэлэг буюу 7 хувь их, 83 буюу 72 хувь дунд, 24 буюу 21 хувь нь бага эрсдэлтэй үнэлэгдсэн. Илэрсэн зөрчлийг үндэслэн улсын байцаагчид 60 эмнэлэгт 310 заалт бүхий хугацаатай албан шаардлагаар үүрэг даалгавар өгч ажилласан байна. Хяналт шалгалт үргэлжилж байна.	98 % — 96.
	Дэд арга хэмжээ 2.1.1. Өмнөговь аймагт-5, Дорнод аймагт-4, Улаанбаатар-2 нийт 11 эмнэлэгт төлөвлөгөөт хяналт шалгалт хийнэ.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	-	40%	-СХГ-аас Дорнод, Өмнөговь аймагт төлөвлөсөн 9, Улаанбаатарт 1 (ХСҮТ) нийт 10 эмнэлэгт хяналт шалгалт хийхэд 4 буюу 40 хувь их, 5 буюу 50 хувь “дунд, 1 буюу 10 хувь бага эрсдэлтэй үнэлэгдэж, илэрсэн дутагдлыг арилгуулахаар 237 заалттай 9 албан шаардлагаар хугацаатай үүрэг өгсөн. -Өмнөговь аймгийн 5 эрүүл мэндийн байгууллагад хийсэн төлөвлөгөөт шалгалтын дүнг Удирдлагын зөвлөлийн хурлаар 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр хэлэлцүүлж, ЭТБГ, СТГ, НЭМБГ, Өмнөговь аймгийн ЭМГ-тай холбоотой гарсан 5 шийдвэрийг дээрх газруудад хүргүүлсэн.	2025.02.01 2025.09.25 2025.03.01 2025.05.30

	Дэд арга хэмжээ 2.1.2. Улсын хэмжээнд эмнэлгүүдэд төлөвлөгөөт хяналт шалгалтын хамтарсан удирдамж боловсруулж батлуулна.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	-	10%	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 420 дугаар тогтоолоор батлагдсан төлөвлөгөөнд их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн эмнэлгүүдийн үйл ажиллагаанд Эрүүл мэндийн сайдын А/496 дүгээр тушаалаар баталсан хяналт шалгалтад хамрагдах 353 объектийн жагсаалтыг холбогдох газартай уялдуулан Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газрын хамтарсан удирдамжийг 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр 10-00/05 дугаартай удирдамжийг батлуулж, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газруудад албан бичгээр хүргүүлсэн.	2025.01.01 2025.02.25	
	Дэд арга хэмжээ 2.1.3: Улсын хэмжээнд (346) эрүүл мэндийн байгууллагад хийсэн хяналт шалгалтын дүнг нэгтгэн, танилцуулга бичиж, удирдлагад танилцуулна.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	2024 онд төлөвлөгөөт хяналт шалгалтын танилцуулга гаргасан.	ЭМС-ын 2024 оны А/496 дугаар тушаалаар зарласан эмнэлгүүдэд хяналт шалгалт хийсэн байна.	-Улсын хэмжээнд эхний хагас жилд 256 эмнэлэгт төлөвлөгөөт шалгалт хийхэс 250 эмнэлэгт хийж, хамралт 98 хувьтай байна. Шалгалтад хамрагдсан 250 эмнэлгийг хяналтын хуудсаар үнэлэхэд 97 буюу 40 хувь нь “бага”, 121 буюу 48 хувь нь “дунд”, 32 буюу 12 хувь нь “их” эрсдэлтэй үнэлэгдсэн байна. Илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах зорилгоор 195 эмнэлэгт 3017 заалт бүхий албан шаардлагаар хугацаатай үүрэг өгч, хялбаршуулсан журмаар 6 ААН, иргэнд 11 000 000 (арван нэгэн сая) төгрөгийн шийтгэвэр ногдуулж, барагдуулсан. Хяналт шалгалтын явцад давхардсан тоогоор нийт 3017 зөрчил, дутагдал илрүүлж, 25 хувь (755)-ийг газар дээр нь арилгуулж, ажилласан. Эмчилгээний чанарын хяналтын чиглэлээр гүйцэтгэлийн хяналтыг 42 эмнэлэгт буюу 22 хувьд албан	2025.09.25 2025.10.10	

					шаардлагаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг үнэлсэн байна. Хяналт шалгалт үргэлжилж байна.		
		Удирдлагын зөвлөлийн хурлын шийдвэр	1	Удирдлагын зөвлөлийн хурлын шийдвэр гаргуулсан.	Хугацаа болоогүй.	2025.09.25 2025.10.10	
4.	Арга хэмжээ 2.2. TXШТХ-ийн 5.3. Хүүхэд, өсвөр үеийн кабинетийн үзүүлж буй тусlamж үйлчилгээнд урьдчилан сэргийлэх хяналт хийх ажлыг зохион байгуулна.	Хяналт шалгалтын нэгдсэн танилцуулга	-	9 дүгээр сард хяналт шалгалтын дүнгийн нэгдсэн танилцуулга гарсан байна.	Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх удирдамжинд заагдсан эмчилгээ, оношилгооний тусlamж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын чиглэлээр 8 асуудлын хүрээнд Бусийн оношилгоо эмчилгээний төв (БОЭТ), Аймгийн нэгдсэн эмнэлэг (АНЭ), Уламжлалт анааах ухааны нэгдсэн эмнэлэг (УАУНЭ), Дүүргийн эрүүл мэндийн төвүүдэд 2025 оны 03 сараас 07 сарыг дуустал хяналт шалгалт хийх ажлыг зохион байгуулсан.	2025.02.01 2025.09.30	100%
	Арга хэмжээ 2.2.1. Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх хамтарсан удирдамж боловсруулж, батлуулна.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	-	Урьдчилан сэргийлэх шалгалт хийх удирдамж батлагдсан байна.	-Салбарын хяналтын газрын даргаар 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр 10-00/04 удирдамжийг батлуулж, аймаг, нийслэлийн эмчилгээний чанарын хяналтын улсын байцаагч наарт хүргүүлж, хяналт шалгалт явагдаж байна. Булган, Сэлэнгэ, Завхан аймгуудад нийт (4 газар) эмчилгээний чанарын хяналтын улсын байцаагч байхгүй байгаа тул урьдчилан сэргийлэх хяналт хийгдээгүй болно.	2025.02.01 2025.02.28 <i>36.</i>	
	Арга хэмжээ 2.2.2: Урьдчилан сэргийлэх шалгалт хийнэ. (Дорнод,	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд	-	40%	Салбарын хяналтын газрын даргын баталсан 10-00/04 удирдамжийн хүрээнд төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдсан Өмнөговь, Дорнод аймгийн	2025.02.01 2025.08.20	

	Өмнөговь)	эзлэх хувь			Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн хүүхэд, өсвөр үеийн тусlamж үйлчилгээ үзүүлж байгаа кабинетэд хяналт шалгалт хийгдсэн. Шалгалтад Өмнөговь аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвд хүүхэд өсвөр үеийн кабинет ажиллахгүй, Дорнод аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвд хүүхэд өсвөр үеийн кабинет нь 2025 оны 03 сараас эхлэн аймгийн Эрүүл мэндийн газрын харьяанд ажиллаж байгаад шилжин ирсэн. 1 хүүхдийн их эмч, 1 эх баригч ажиллаж байна. Одоогоор үйл ажиллагаа нь жигдэрээгүй байна. Иймд Өмнөговь, Дорнод аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд хүүхэд, өсвөр үеийн кабинетийг нээж ажиллуулах, үйл ажиллагааг нь тогтмолжуулж ажиллах талаар улсын ахлах байцаагчийн албан шаардлагад 4 заалтыг хугацаатай өгч ажиллав.		
	Арга хэмжээ 2.2.3: Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын дүнг нэгтгэж, танилцуулга бичиж, удирдлагад танилцуулна.	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	-	50%	Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад эмчилгээний чанарын хяналтаар эхний хагас жилд төлөвлөгөөт хяналт шалгалтаар зарлагдсан БОЭТ, НЭ УАУНЭ, Дүүргийн эрүүл мэндийн төвүүдэд хүүхэд, өсвөр үеийн тусlamж үйлчилгээ үзүүлж байгаа 20 эмнэлэг хамрагдахаас 22 эмнэлэгт урьдчилан сэргийлэх шалгалт хийгдсэн. Үүнээс 7 аймгийн 7 эмнэлэгт хүүхэд өсвөр үеийн кабинет ажиллахгүй байна.(ДОА, ДУА, Орхон, ӨМА БОЭТ, СБАНЭ, УАУНЭ,	2025.08.01 2025.09.30 <i>Н/з жз.</i>	

					Dорнод УАУНЭ) Үйл ажиллагаа явуулж буй 15 эмнэлгийн 13 (86%) нь нийгмийн ажилтан, сэтгэл зүйч дутагдалтай, 8 (53%) нь өсвөр үеийн нийгмийн болон эмнэлгийн тусlamж үйлчилгээний багцын хүртээмж, чанар хангалтгүй, 9 (60%) нь өсвөр үеийн хүүхдийн бүртгэл, өвчлөлийн судалгаа, шилжилт хөдөлгөөний мэдээллийн сан үүсгэж, баяжилт хийгээгүй, 10(66%) нь Өсвөр үеийн кабинетэд хөтлөгдөх хүчин төгөлдөр эмнэлгийн анхан шатны маягтыг асуумжийн дагуу бүрэн хөтөлж хэвшээгүй, 15 (100%) нь өсвөр үеийнхэнд сэтгэл зүйн оношилгоо хийх, зөвлөлгөө өгөх, эрсдэлтэй зан үйлийг илрүүлэх, хариу арга хэмжээ авч, тусlamж үйлчилгээ үзүүлээгүй зэрэг 155 зөрчил илэрч 16 хувь (25)-ийг арилгуулан, 18 эмнэлэгт 137 заалттай албан шаардлага өгсөн байна. Хүүхэд, өсвөр үеийн 10 эмнэлгийн кабинетийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх хугацаа болоогүй байна. 2025 оны 10 дугаар сарын 30-ны дотор нэтгэж, төлөвлөгөөт хяналт шалгалтын дүнтэй хамт удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ. Хугацаа болоогүй.		
5.	Арга хэмжээ 2.3. Иргэн, ААН, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр	Өргөдөл гомдлын шийдвэрлэлт, хувь	2024 оны танилцуу лга	Ирсэн өргөдөл гомдлыг 100% бүрэн шийдвэрлэс	2025 оны эхний тайлант хугацаанд хариуцсан хяналтын чиглэлээр 10 өргөдөл, гомдол 36 албан бичиг ирж, 29 албан бичигт хариу хүргүүлсэн. Байгууллага, иргэнээс ирүүлсэн нийт 11	2025.01.01 2025.12.29	100%

	төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийнэ			эн байна.	<p>өргөдөл гомдлыг хүлээн аваад 2 иргэний ирүүлсэн гомдлыг Эрүүгийн хуулийн 15.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.3 дахь заалтад заасан гэмт хэргийн шинжтэй тул гомдлыг Цагдаагийн байгууллагад, 1 иргэний гомдлыг Дорноговь аймгийн ЭМГ-т харьяаллын дагуу шилжүүлсэн. 1 гомдлыг ЭМЯ-ны эмч эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороонд шилжүүлсэн.</p> <p>-2 эмнэлгийн эмч наrtай холбоотой гомдолд зөрчлийн хэрэг нээж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж, 1(ЭНЭҮТ2)төвийн эмч наrt илэрсэн зөрчлийг үндэслэн Зөрчлийн тухай хуулийн дагуу гомдлыг прокурорын гомдол мэдээлэлийн нэгдсэн санд ЭМЯ-08 дугаартай бүртгүүлж, зөрчлийн талаархи гомдол, мэдээллийг гэмт хэргийн шинжтэй үндэслэлээр Эрх бүхий албан тушаалтны саналаар (ЗХБ 29) харьяаллын дагуу Хан-уул дүүргийн цагдаагийн 2 дугаар хэлтэст шилжүүлэхээр прокурорт хүргүүлэв.</p> <p>-Цэргийн төв эмнэлгийн 2 эмчид хариуцлага тооцуулах саналыг хүргүүлж, эргэн хариуцлага тооцсон тухай албан бичиг ирүүлсэн.</p> <p>-“Өмнөговь аймгийн Булган сумын эрүүл мэндийн төв”-ийн эмч наrtай холбоотой ирүүлсэн гомдлын дагуу хяналт шалгалт хийж, төвийн хэмжээнд эмч мэргэжилтнүүд нь үйл ажиллагаандаа эрүүл мэндийн тухай хууль тогтоомж, оношлогоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх ажлын стандарт, технологи,</p>		
--	--------------------------------------	--	--	-----------	---	--	--

					<p>эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх удирдамжийг мөрдөж ажилладаггүй, эмнэлгийн удирдлага, зохион байгуулалт сул, эмч, мэргэжилтнүүдийн ажлын хариуцлага хангалтгүй байгаатай холбоотой байна.</p> <p>Иймд алдаа дутагдал гаргасан их эмч, сувилагч нарт төвийн даргын тушаалаар хариуцлага тооцуулж, тус байгууллагад илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын ахлах байцаагчийн хамтарсан албан шаардлага хүргүүлсэн ба эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрмийн хэм хэмжээг зөрчсөн эмч, мэргэжилтэнүүдийг Эрүүл мэндийн газрын дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны хурлаар хэлэлцүүлж, Зөрчлийн тухай хуулийн 11.2 дугаар зүйлийн 1.2 дахь заалтын дагуу шийтгэвэр ногдуулах арга хэмжээ авч ажилласан болно.</p> <p>-Эмнэлэг, эмчийн үйл ажиллагаатай холбоотой 7 гомдолд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, 3 иргэний гомдолыг мэдээллийн нэгдсэн бүртгэлд оруулж, зөрчлийн хэрэг нээж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа хийгдэж, удирдлагад танилцуулж, иргэн байгууллагаас ирүүлсэн 6 гомдолд дурдсан асуудал үндэслэлтэй нь тогтоогдсон.</p> <p>Иргэний ирүүлсэн 1 гомдол үндэслэлгүй байсан.</p> <p>Шийдвэрлээгүй өргөдөл гомдол байхгүй.</p> <p>-Салбарын хяналтын газрын даргын</p>	
--	--	--	--	--	---	--

					<p>баталсан 10-00/20 удирдамжийн хүрээнд эмчилгээний чанарын хяналтын чиглэлээр Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын Хяналтын шалгалтын 17 хэлтсээс 114 эрүүл мэндийн байгууллагуудад төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж гүйцэтгэсэн.</p> <p>Нийслэлд Эх нярай эрүүл мэндийн төв-2, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, 5 дүүргийн 5 ЭМТ, 4 дүүргийн 4 нэгдсэн эмнэлэг, Сэлбэ нэгдсэн эмнэлэг, Хантуул Сэргээн засах төв, 6 дүүргийн 30 өрхийн эрүүл мэндийн төв нийт 43 эрүүл мэндийн байгууллага, 16 аймгийн 45 ΘЭМТ, 14 аймгийн нэгдсэн эмнэлэг 11 Бусийн оношилгоо эмчилгээний 4 төв, 5 аймгийн 11 сумын эрүүл мэндийн төв нийт 71 эрүүл мэндийн байгууллага хамрагдсан.</p> <p>Дүгнэлт: Төлөвлөгөөт бус хяналт шалгалтын удирдамжид заагдсан асуудлын хүрээнд эрүүл мэндийн 114 байгууллагад Эрүүл мэндийн сайдын 2024 оны Улаан бурхан өвчний тархалтаас сэргийлэх зарим арга хэмжээний тухай 08 дугаар албан даалгаврын биелэлт 50.2 хувь хангалтгүй дүгнэгдэж байгаа, тулгамдаж буй асуудлын талаар бичиж, танилцуулгын нэгтгэлд өгч удирдлагуудад танилцуулсан.</p>		
6.	Арга хэмжээ 2.4. Хяналт шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгж байгууллагад дотоод хяналтыг нэвтрүүлэх	Сургалтын тайлан	-	Хяналт шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгж	-Эхний хагас жилд төлөвлөгөөт шалгалтад хамрагдсан 250 эмнэлгийн 60 хувь буюу 155 эмнэлгийн 2325 хүнд хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга зам болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх талаар	2025.02.01 2025.06-06	100%

	чиглэлээр сургалт зохион байгуулна.			байгууллагын 50-иас доошгүй хувийг хамруулан сургалт зохион байгуулсан байна.	байгууллагын сургалт хийж ажилласан байна. -СХГ-аас Дорнод,Өмнөговь аймаг, Улаанбаатарт ХСҮТөвд төлөвлөгөөт хяналт шалгалт хийсэн 10 эмнэлгийн 150 хүнд дотоод хяналтыг төлөвшүүлэх, тогтмолжуулах чиглэлээр сургалт мэдээлэл хийж ажилласан.		
--	-------------------------------------	--	--	---	--	--	--

Зорилт.3.“Улсын байцаагчдын чадавхийг сайжруулна.

7.	Арга хэмжээ 3.1. ЭМС-ын 2024 оны А/309 дүгээр тушаалтын 6 дугаар хавсралтын 2.1.1 Орон нутаг дахь улсын байцаагчдыг чадавхижуулах сургалтыг давтан зохион байгуулна.	Сургалтын тайлан	2	Сургалт зохион байгуулсан нэгдсэн тайлан гаргасан.	-Эмчилгээний чанарын хяналтын улсын байцаагч нараас сургалт авах хэрэгцээг тодорхойлж, хэрэгцээний судалгаанд үндэслэн эмчилгээний чанарын хяналтын улсын байцаагч нарт “Хүүхдийн эрэмбэлэн ангилалт, яаралтай тусламж” чиглэлээр сургалтыг 2025 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 15.00-17.30 цагийн хооронд баталсан хөтөлбөрийн дагуу цахим сургалтыг зохион байгуулж, эмчилгээний чанарын хяналтын улсын 22 байцаагчид хамруулсан. Хөтөлбөрийн дагуу Манас таталтын урьдал үеийн оношилгоо, эмчилгээний зарчим, хүүхдийн эрэмбэлэн ангилалт, яаралтай тусламж авах арга хэмжээ зэрэг сэдвийн хүрээнд хийгдэж, улсын байцаагч нарын мэдлэг нэмж, мэдээлэл өгсөн ач холбогдолтой сургалт болсон. -Эмчилгээний чанарын хяналтаар 2025 оны 02 дугаар сард аймаг, нийслэлийн 25 улсын байцаагч нарт цахимаар 2025 оны зөвлөмж, төлөвлөлт, төлөвлөгөөт хяналт шалгалт, урьдчилан сэргийлэх,	2025.02.01 2025.06-06	100%
----	---	------------------	---	--	---	--------------------------	------

					хяналтын хуудсны шинэчлэл, цаашид анхаарах асуудлаар сургалт хийж, чиглэл өгсөн.		
	Дүн						%

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур Үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		Эхэлсэн, дууссан хугацаа
1.	Арга хэмжээ 1. Мэргэжлийн чиглэлийн чадавхижуулах сургалтад хамрагдана.	Суралцсан кредит цаг	-	1	2025 оны 03 дугаар сарын 28-ний өдөр АШҮҮИС-ийн харьяа биоанагаахын сургуулиас зохион байгуулсан "Эмнэлзүй эмгэг судлалын онош, түүний хэлбэржилт, оношийн зөрөө, алдаа эмнэлгийн тусламж үйлчилгээнд тулгамдаж буй асуудлууд" сэдэвт багц цагийн сургалтад хамрагдаж 2 багц цаг авч, мэдлэгээ нэмэгдүүлсэн.	2025.03.28 2025.03.30	100%
2.	Арга хэмжээ 2. Хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбоотой болон хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх сургалтад хамрагдана.	Хамрагдсан сургалтын тоо	-	1	NICE олон улсын байгууллагаас зохион байгуулсан "Монгол дахь эрүүл мэндийн технологийн үнэлгээг институуцилах" сэдэвт сургалтанд 2025 оны 03 дугаар сарын 19-21-ны өдөр танхимаар сууж, гэрчилгээ авч, эмнэлгийн хууль эрхзүйн мэдлэгээ дээшлүүлсэн.	2025.03.19 2025.03.21.	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ
(Албан тушаал)

Б. Байгальмаа/
(Нэр, гарын үсэг)

2025.06.10
(Огноо)